

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн
хэрэгжилтэд хяналт- шинжилгээ үнэлгээ хийсэн тухай
(2023 оны жилийн эцэс)

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д (374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон) үндэслэн байгууллагын хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэв.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээ, тайланг Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтан Ю.Хүслэнгээс 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хүлээн авч, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалаар дүгнэлээ.

6.3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно:

6.3.1.“Бүрэн хэрэгжсэн”- холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь)

6.3.2.“Хэрэгжих шатанд”-т тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-90 хүртэл хувь)

6.3.3.“Хэрэгжилт хангалтгүй”-т тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт, хийгдэж дууссан боловч зохион байгуулалт төсөв санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-50 хүртэл хувь)

6.3.4.“Хэрэгжээгүй” тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулагдаагүй бол 0 хувь (0-10 хүртэл хувь)

Монгол Улсын 5 хуулийн 9 заалт, Засгийн газрын 8 тогтоолын 18 заалт, Монгол улсын Ерөнхий сайдын албан даалгаврын 1 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 тогтоолын 1 заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн Засаг даргын 11 захирамжийн 11 заалт, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 4 тэмдэглэлийн 7, нийт 7 захирамжлалын баримт бичгийн 49 заалтыг хяналтад авч, холбогдох нэгж, албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд хэрэгжилтийг дараах байдлаар үнэлэв.

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ,
ДЭЭД ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

2023 он

	Бүгд	үүнээс										
		Монгол Улсын хууль	УИХ-ын тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Ерөнхий сайдын албан даалгавар	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	НИТХ-ын тогтоол	НИТХ-ын Тэргүүлэгчийн тогтоол	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн	Нийслэлийн Засаг даргын захирамж	
Хяналтанд авсан тогтоол шийдвэрийн тоо	32	5	-	-	1	8	-	1	2	4	11	
Хяналтанд авсан нийт зүйл заалтын тоо	49	9	-	-	1	18	-	1	2	7	11	
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100)	34	6	-	-	1	10	-	1	1	5	10
	Хэрэгжих шатанд 70% (50-90)	15	3	-	-	-	8	-	-	1	2	1
	Хэрэгжилт хангалтгүй 30% (50-90)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжээгүй 0% (0-10)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Үүнээс:	Зохион байгуулалтаас шалтгаалсан										-	
	Хөрөнгө дутагдсанаас шалтгаалсан										-	
Биелэлтийн дундаж хувь											90.8%	

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар агуулга	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь	Тайлбар
1	2	3	4	5	6
1. Монгол Улсын хууль					
1	55.3		Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 2021-2024 оны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг жил тутам гарган ажиллаж байна. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг хамруулах 2023 оны сургалтын төлөвлөгөө 02 сарын 14-ны өдөр	"Хэрэгжих шатанд"- 70% 1.Байгууллага албан хаагчдын сургалтын төлөвлөгөө болон ажиллах нөхцөл	-

		<p>Төрийн албаны тухай 2017.12.07 Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>батлагдсан бөгөөд нийт 25 арга хэмжээ тусгагдсан, Нийгмийн баталгааг хангах чиглэлээр 3 бүлгийн 24 арга хэмжээ тусгагдсан ба дээрх хөтөлбөрүүдийн хэрэгжилт 100% байна.</p> <p>Тайлант хугацаанд дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулсан 20 сургалт болон үйл ажиллагаа зохион байгуулагдсан үүнээс байгууллага дотооддоо зохион байгуулсан сургалт 8, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 12 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан ба байгууллага дотооддоо зохион байгуулсан сургалтуудад давхардсан тоогоор 1238 албан хаагч хамрагдсан байна. Ажилтан, албан хаагчдыг ажлын гүйцэтгэл үр дүнг улирлаар дүгнэн 128,348,169 төгрөгийн үр дүнгийн урамшуулал, үр чадварын нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл илүү цагийн болон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг зохих хууль, журмын дагуу 260 гаруй ажилтан, албан хаагчид нийт 946,987,100 төгрөгнийн нэмэгдэл хөлсийг олгосон. 2023 оны жилийн эцсийн байдлаар 531,758,800 төгрөгийн унаа, хоолны зардал олгосон.</p> <p>Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу буцалтгүй тусламжийг 1 ажилтанд 1.000.000 төгрөг, нас барсны тэтгэмж 11 хүнд 3.300.000 төгрөг, өндөр настны тэтгэвэрт гарсан 6 ажилтанд 109.586.627 төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламжийг тус тус олгосон байна. Цагаан сарын баяр болон ахмадын баяраар өндөр настанд 10.650.000 төгрөг зарцуулсан болно.</p> <p>Үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 27 ажилтан, албан хаагчдын ажил байдлын тодорхойлолтыг боловсруулан холбогдох газарт нь хүргүүлэн ажилласан. Монгол Улсын Засгийн газар, салбар яамны шагналаар 4, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн “Хүндэт тэмдэг”-ээр 3, “Хүндэт өргөмжлөл”-өөр 3, “Хүндэт үнэмлэх”-ээр 3, Нийслэлийн Засаг даргын “Нийслэлийн тэргүүний ажилтан” тэмдгээр 2, “Жуух бичиг”-ээр 6, Байгууллагын “Шилдэг ажилтан”-аар 5 ажилтан, албан хаагч тус тус</p>	<p>нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөнд хэдэн арга хэмжээ төлөвлөсөн, жилийн эцсийн байдлаар хэдэн хувийн биелэлттэй байгаа талаар тусгах, 2.Бичвэр хэтэрхий нуршуу, 2000 тэмдэгтэд багтаагаагүй.</p>	
--	--	--	--	---	--

			шагнуулсан байна.		
2	8.1	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай</p> <p>2021.12.17</p> <p>Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль шинэчлэгдэн 2022 оны 05 дугаар сарын 1-ны өдрөөс “Цахим хөгжлийн багц хууль” Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулиар нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл гэж ангилсан бөгөөд хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэл болох Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүү, хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг www.khangardi.mn сайт, болон мэдээллийн самбарт цахим болон цаасан суурьтайгаар байршуулан ажиллаж байна.</p>	"Хэрэгжих шатанд"- 70%	-
3	8.2	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай</p> <p>2021.12.17</p> <p>Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.</p>	<p>Тус газар нь байгууллагын дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, дүрмээр хүлээсэн чиг үүрэгт нийцүүлж, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнг тухай бүр байгууллагын цахим хуудаст шинэчлэн, нээлттэй байршуулж ажиллаж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын А/93 дугаар захирамжаар батлагдсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтын схемийг мэдээллийн самбар, цахим хуудаст тогтмол байршуулж ажилласан.</p> <p>http://khangardi.mn/?page_id=3634</p> <p>http://khangardi.mn/?page_id=3648</p> <p>http://khangardi.mn/?page_id=3868</p>	"Бүрэн хэрэгжсэн" 100%	-
4	8.3	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай</p> <p>2021.12.17</p> <p>Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.</p>	<p>Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд нээлттэй зарлаж байна. Тайлант хугацаанд 44 удаагийн давтамжтай сул орон тооны зарын хүргүүлж 85 горилочг материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн ба анкет хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж,</p>	"Бүрэн хэрэгжсэн" 100%	-

			<p>79 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийн хянаж, үнэлэх журмыг цахим хуудсанд байрлуулсан. Ажилтан, албан хаагчдын ур чадварыг холбогдох журмын дагуу улирал бүр дүгнэж, ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын хавсалтын дагуу ур чадварын нэмэгдлийг сар бүр олгосон бөгөөд энэ талаарх мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулж ажиллалаа.</p>		
5	8.4	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021.12.17 Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана.</p>	<p>Тайлант хугацаанд төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах үүднээс заасан хугацаанд тухай бүр тайлан, мэдээг гаргаж, www.shilendans.gov.mn, тайлагнаж, байгууллагын цахим хуудас http://khangardi.mn/?page_id=3583 төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулан ажиллаж байна.</p>	<p>"Хэрэгжих шатанд"- 70% Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой хэдэн төгрөгийн, хэдэн төрлийн мэдээллийг хэдэн удаа /давтамж/ байршуулсан талаарх мэдээлэл байхгүй.</p>	-
6	31.1	<p>Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2021.12.17</p> <p>Энэ хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг устгана.</p>	<p>Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар ажлын хэсэг томилогдож хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан (Хурууны хээ) биеийн давхцахгүй өгөгдлийг устгах үйл ажиллагааг зохион байгуулсан. Нийслэлийн Засаг захиргааны 4-н байр, нийт 154 ажилтан албан хаагчийн хурууны хээ агуулж буй файл, өгөгдлийн баазыг устгаж, давхцахгүй хувь хүний биометрик өгөгдөл болох нүүр царайгаар таниулах системд</p>	<p>"Бүрэн хэрэгжсэн" 100%</p>	
7	5.1	<p>Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.29 Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд,</p>	<p>2023 онд бүтэц, орон тоог батлахдаа орлогч даргатай ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалах зэрэг хуулийн зөрчилгүй гаргалгүй ажиллаж байна.</p>	<p>"Бүрэн хэрэгжсэн" 100%</p>	-

		дэд, орлогч даргатай байхыг хориглоно.			
8	12.1	Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно	Гар утасны зардал, ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал, хэвлэлийн захиалгын төлбөр, хуулиар зөвшөөрөөгүй бусад зардлыг байгууллагын төсвөөр гаргалгүй хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	"Бүрэн хэрэгжсэн" 100%	
9	13.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023.05.04 Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно.	Газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний А/52 дугаар тушаалаар газрын "Ёс зүйн дэд хороо"-г байгуулж, ёс зүйн дүрмийг баталсан. Ёс зүйн дэд хорооны гишүүд 2023 оны 11 дүгээр сарын 06-ний өдөр анхны хуралдаанаа зохион байгуулж, дэд хорооны даргыг сонгосон.	"Бүрэн хэрэгжсэн" 100%	
5 хуулийн 9 заалтын хэрэгжилтийн дундаж хувь 90%					
2. Засгийн газрын тогтоол					
1	1.1	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх	Ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг сахиулах арга хэмжээний хүрээнд тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал: Ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаар шат дараалсан арга хэмжээ авч, ажлаас хоцорсон, эрт тарсан болон хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цагаа дутуу бүртгүүлсэн ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг тооцоходоо холбогдох журмын дагуу хасаж тооцож байна. Сахилга хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан ажилтан албан хаагчдын зөрчлийн талаарх мэдээллийг нээлттэй хүлээн авч, зөрчлийн шинжийг шалган Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг 5 ажилтан, албан хаагчдад ногдуулсан.	"Бүрэн хэрэгжсэн" 100% Үр дүн- 2022 онд 9 ажилтан холбогдох сахилгын болон ёс зүйн зөрчил гаргаж зөрчлийн тоо өмнө оны мөн үетэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.	-
2	1.2	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 №	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас нийт 220 өргөдөл ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод	"Бүрэн хэрэгжсэн" 100%	-

		2020_258 Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх	удирдлагын нэгдсэн систем /https://erp.ulaanbaatar.mn /-д бүртгэн, 219 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан бол 1 өргөдөл шийдвэрлэх шатанд, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл гомдол 2 байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 7 хоног 10 цаг 44 минут бөгөөд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 3 өдрөөр буурсан үзүүлэлттэй байна.		
3	1.3	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258 төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах	Газрын даргын 2023 оны А/01 дугаар тушаалаар тухайн жилд хамаарах ажил, албан тушаалын бүтцийн жагсаалтыг шинэчлэн баталснаар албан хаагчдын ажил үүргийн зөв, жигд хуваарилан ажлын ачааллыг бууруулсан. 2022 оны 01 сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ээлжийн амралттай байгаа ажилтныг орлон ажиллуулж, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Төрийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Мөн цаг үеийн шинж чанартай үйл ажиллагаа, арга хэмжээний үеэр ажилтан, албан хаагчдын ажлыг цагийн зөв зохион байгуулах газрын даргын 2023 оны 06 сарын 02-ны өдөр баталсан Зоогийн газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, 11 дүгээр сарын 16-ний өдөр баталсан 06 дугаар удирдамжийн дагуу Нийслэлийн засаг захиргааны байруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж албан хаагчдын ажлын ачааллыг судлан ачааллыг жигд хуваарилах, ажлын байрны давхардал хийдэл үүсгэхгүй, нэг ажилтанд хэт их ачаалал өгөхгүй байх талаар арга хэмжээг авсан.	"Хэрэгжих шатанд"- 70%	-
4	1.4	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг	Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасан чадахуйн (мерит) болон шатлан	"Бүрэн	-

		<p>чангатгах тухай 2018.08.22 № 2020_258</p> <p>төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх</p>	<p>дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажиллаж, албан хаагчийн ур чадвар, дадлага туршлага, ёс зүйн харилцаа хандлага, мэдлэг боловсрол зэрэг үзүүлэлтийг харгалзан 6 албан хаагчийг дэвшүүлэн томилсон байна. Дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтныг хүний нөөцийн ахлах мэргэжилтнээр, өргөдөл гомдол хариуцсан ажилтныг хүний нөөц сургалт хариуцсан ажилтнаар, 2 тогоочийг ахлах тогоочоор, бичиг хүргэгчийг байр хариуцсан менежерээр, хүнсний бүтээгдэхүүн хангамжийн нярвыг тооцооны нягтлан бодогчоор тус тус дэвшүүлэн томилсон байна.</p>	<p>хэрэгжсэн” 100%</p> <p>Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоог нөхөх тухай заалт тул хасах саналтай байна.</p>	
5	1.6	<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018.08.22 № 2020_258</p> <p>Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх</p>	<p>Жирэмсний болон амаржсаны амралт, хүүхэд асрах чөлөөтэй байгаа 31 ажилтан албан хаагч, хувийн болон эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны чөлөөтэй байгаа 2 албан хаагч, нийт 80 албан хаагчийн ажлын байрны сул орон тоонд мөн тооны ажилтан, албан хаагчийг хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж байна.</p>	<p>Бүрэн хэрэгжсэн” 100%</p>	-

6	1.7	<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</p> <p>2018.08.22</p> <p>№ 2020_258 төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох</p>	<p>Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл 2 удаа хуралдаж 3 ажилтан, албан хаагчид холбогдох зөрчлийн шинж чанартай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн ба хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасан зөрчил гаргасан 2 алба хаагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 123-р зүйлд заасан үндэслэлээр сануулах сахилгын шийтгэл оногдуулсан.</p>	Бүрэн хэрэгжсэн” 100%	-
7	1.8	<p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</p> <p>2018.08.22 № 2020_258</p> <p>төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах</p>	<p>Ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттай ажлууд хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц хөгжлийн төвтэй хамтран “Жендерийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо” сэдэвт 3 цагийн сургалтад 141 албан хаагч, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас “Ээлтэй орчин бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг 20 албан хаагчид, Нийслэл Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоотой хамтран “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эвлэлдэн нэгдэх эрх ба Хамтын гэрээ байгуулахын давуу тал, ач холбогдол” сэдвийн хүрээнд нийт 4 цагийн багц сургалтыг Захиргаа төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн нийт 32 ажилтан, албан хаагчдад мэдлэг, мэдээлэл олгосон.</p>	”Хэрэгжих шатанд”- 70%	-

8	5.1	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05</p> <p>Дугаар 7</p> <p>Эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх.</p>	<p>Захиргааны байгууллагуудын нэрийг уйгаржин монгол бичиг рүү хөрвүүлэх, нэр томъёог орчуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна.</p> <p>Мөн Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нэрийг монгол бичгээр хөрвүүлсэн.</p>	"Хэрэгжих шатанд"- 70%	-
9	5.2	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05</p> <p>Дугаар 7</p> <p>Төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх</p>	<p>Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын албан ёсны сайт www.khangardi.mn кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтлэх үйл ажиллагааг туршилтаар хэрэгжүүлэн ажилласан.</p>	"Хэрэгжих шатанд"- 70%	-
10	5.3	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05</p> <p>Дугаар 7</p> <p>Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших</p>	<p>Байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч нь Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Монгол бичгийг хэрэглээнд албан ёсоор шилжих бэлтгэл ажлыг хангах, түүний бүрдэлд тавигдах үндсэн шаардлагыг судлан, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	"Хэрэгжих шатанд"- 70%	-
11	5.4	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05</p> <p>Дугаар 7 Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх</p>	<p>Монгол бичгийг төрийн бичиг болгохтой холбогдуулан уйгаржин монгол бичгийг албан хэрэгцээнд нэвтрүүлэх бэлтгэлийг ханган холбогдох сургалт МУЗГ-ын 7 дугаар тогтоол, НЗД-ын 02-03/373 хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд 2023 оны 08 дугаар сарын 30, 09 дүгээр сарын 14-ний өдрүүдэд Нийтлэг үйлчилгээний газрын байр хариуцсан менежер, монгол хэл бичгийн багш Б.Мөнхцэцэг нь Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 50 албан хаагчдад нийт 14 цагийн хичээл заахаар төлөвлөснөөс 2 цагийн танхим, 6 цагийн цахим хичээлийг зохион байгуулан, мэдээлэл арга зүйгээр ханган</p>	"Хэрэгжих шатанд"- 70%	-

			ажиллалаа.		
12	5.5	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.01.05 Дугаар 7 Төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/897 дугаар "Гадна хаягийн загвар батлах тухай" захирамжийн дагуу Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хаягжилт болон давхрын мэдээллийн самбарыг уйгаржин монгол бичгээр бичин ажиллаж байна..	"Хэрэгжих шатанд"- 70%	-
13	2	Журам шинэчлэн батлах тухай 2020.12.09 Дугаар 206 Энэ журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал боловсруулан баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Дотоод хяналт, Хяналт, үнэлгээ шинжилгээ хариуцсан ажилтан Засгийн газрын 206 дугаар тогтоолын дагуу нийт алба хаагчдын тайланд хяналт, үнэлгээ шинжилгээ хийн ажиллаж байна.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	-
14	3	2023-2024 оны авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023.02.08 Дугаар 49 Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. ХАСУМ мэдүүлэх шаардлагатай албан тушаалд Авлигатай тэмцэх газраас ирсэн албан бичгийн дагуу томилгоог хийн хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргасан. Албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлагын мэргэжлийн болон боловсролын зэргийн шаардлага хангахгүй нийт 3 албан хаагчийг эрхэлж буй албан тушаалаас чөлөөлж, албан тушаалын тодорхойлолтын тусгай шаардлага хангаж буй сул орон тоонд албан тушаал бууруулан шилжүүлэн томилсон.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	-

15	1	<p>Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай 2023.06.21 Дугаар 240</p> <p>Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ыг 6 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн тогтоосугай.</p>	<p>Газрын даргын 2023 оны 07 сарын 04-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгууллагын 69 албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосон. Үүнээс: ТҮ 10 зэрэглэлээр 1, ТҮ 9 зэрэглэлээр 3, ТҮ 8 зэрэглэлээр 5, ТҮ 7 зэрэглэлээр 21, ТҮ 6 зэрэглэлээр 8, ТҮ 5 зэрэглэлээр 5, ТҮ 4 зэрэглэлээр 3, ТҮ 3 зэрэглэлээр 10, ТҮ 2 зэрэглэлээр 4, ТҮ 1 зэрэглэлээр тогтоосон.</p>	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	
16	1	<p>Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023.06.21 Дугаар 241</p> <p>Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг 10 дугаар хавсралт, Төрийн улс төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээг 11 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн тогтоосугай</p>	<p>Газрын даргын 2023 оны 07 сарын 04-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгууллагын нийт албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг шинэчлэн тогтоосон.</p>	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	
17	1.1	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022.05.25 Дугаар 203</p> <p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх</p>	<p>Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд НЗД-ын 2022 оны А/656 захирамжаар Нийтлэг үйлчилгээний газрын гурван орлогч даргыг газрын даргын Б/ 185,186 дугаар тушаалаар 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөр үүрэгт ажлаас нь чөлөөлж тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p>	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	
18	2	<p>Журам батлах тухай 2022.05.18 Дугаар 201</p> <p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга,</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль шинэчлэгдэн 2022 оны 05 дугаар сарын 1-ны өдрөөс "Цахим хөгжлийн багц хууль" Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулиар нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл гэж ангилсан бөгөөд хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэл болох Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон</p>	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	

		төсөвт байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай	хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүү, хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг www.khangardi.mn сайт, болон мэдээллийн самбарт цахим болон цаасан суурьтайгаар байршуулан ажиллаж байна.		
8 тогтоолын 18 заалтын хэрэгжилтийн дундаж хувь 88%					
3. Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар					
1	1.7	Шил ажиллагааг эрчимжүүлэх тухай 2023.04.17 Дугаар 01 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулиар нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл гэж ангилсан бөгөөд хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэл болох Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээлэл үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүү, хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг www.khangardi.mn сайт, болон мэдээллийн самбарт цахим болон цаасан суурьтайгаар байршуулан ажиллаж байна.	"Бүрэн хэрэгжсэн"- 100	-
4. Нийслэлийн Засаг даргын захирамж					
1	1	Журам батлах тухай №2021-А/52/ 2021.02.02 "Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам"-ыг шинэчлэн 1 дүгээр, "Хяналтын дагалдах хуудасны загвар"-ыг 2 дугаар, "Төсөл ирүүлсэн саналын товёгийг загвар"-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.	Нийтлэг үйлчилгээний газар нь захирамжлалын баримт бичгийг гаргахдаа Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/52 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан хяналтын дагалдах хуудасны загварын дагуу боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд газрын даргын 206 тушаалд хяналтын дагалдах хуудасны дагуу боловсруулагдсан байна.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	-

2	1	<p>Журам батлах тухай №2015-А/633 2015.07.29</p> <p>“Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчийн ажил хүлээлцэх журам”-ыг нэгдүгээр, “Ажил хүлээлцэх хуудасны загвар”-ыг хоёрдугаар, Тойрох хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.</p>	<p>Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь ажилтан, албан хаагчтай ажил хүлээлцэхдээ Нийслэлийн Засаг даргын А/633 дугаар захирамжийн хавсралтад заасан, ажил хүлээлцэх хуудасны загвар, тойрох хуудасны загварыг Хөдөлмөрийн дотоод журамд заан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	<p>“Хэрэгжих шатанд”- 100%</p>	-
3	1	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай №2021-А/115/2021.02.26</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020- 2024 оны үйл ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр, Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 2 дугаар хавсралтаар баталсугай.</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “2023 оны төлөвлөгөө” дунд хугацааны бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилтийн явцад улирал бүр тайлан мэдээг гаргаж тайлант хугацаанд 1 удаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн холбогдох газарт заасан хугацаанд тайлганаж ажиллаж байна. Тус хөтөлбөрт Нийслэлийн Нийтлэг Үйлчилгээний газарт тухайлан заасан заалт байхгүй бөгөөд байгууллийн үйл ажиллагаатай уялдуулан мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн тайлан мэдээг тогтмол гаргаж байна.</p>	<p>“Хэрэгжих шатанд”- 100%</p>	-
4	2	<p>Дүрэм шинэчлэн батлах тухай №2022-А/93 2022.01.27 Дүрмийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар (Х.Эрдэнэбилэг)-т хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг НЗДТГ (Т.Оюунчимэг)-т тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/93 дугаар захирамжаар Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, байгууллагын мэдээллийн самбар, khangardi.mn сайтад байршуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж НЗДТГ-ын холбогдох хэлтэст тайлан мэдээг хүргүүлэн ажилласан.</p>	<p>“Хэрэгжих шатанд”- 70%</p>	-
5	2	<p>Нийслэл хотын ялгамж чанарыг илтгэх тэмдгийг батлах тухай №2022-А/768 2022.06.03 Ялгамж чанарыг илтгэх тэмдгийг нийслэлийн бүх шатны төр захиргааны байгууллагууд үйл ажиллагаандаа тогтмол ашиглахыг үүрэг болгосугай.</p>	<p>Нийслэлийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс шингэсэн ялгамж чанарыг илтгэх тэмдгийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилтан албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, үйл ажиллагаандаа тогтмол ашиглахыг үүрэг болгож хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</p>	<p>“Хэрэгжих шатанд”- 100%</p>	-

6		<p>Журам батлах тухай №2023-A/727 2023.07.03 “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.</p>	<p>Байгууллага нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтыг хийхдээ тус журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон тайлант хугацаанд нийт 2 хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан байна. Тодруулбал 2023 оны 11 дүгээр сарын 16-ний өдөр баталсан 06 дугаар удирдамжийн дагуу Нийслэлийн засаг захиргааны байруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн бол газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/51 дугаар тушаалын хавсралтаар баталсан удирдамжийн дагуу зоогийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тус тус хийж ажиллав.</p>	<p>“Хэрэгжих шатанд”- 100%</p>	
7	1	<p>Журам батлах тухай №2023-A/1133 2023.09.25 Нийслэлийн албан ёсны мэдээллийн www.ulaanbaatar.mn цахим хуудас ажиллуулах журмыг 1 дүгээр, цахим хуудасны мэдээллийн цэсийг хариуцан, тухай бүр шинэчлэл хийх байгууллага, нэгжийн жагсаалтыг дугаар хавсралтаар тус тус баталсугай.</p>	<p>Нийслэлийн www.ulaanbaatar.mn цахим хуудаст нийслэлийн нутгийн захиргааны харьяа байгууллагууд сул ажлын байрны зарыг хариуцан мэдээлэхээр заасан бөгөөд ажлын байрны сул орон тооны зарыг тогтмол системд байршуулан мөн Байгууллагын www.khangardi.mn цахим сайт 11 удаа, байгууллагын фэйсбүүк пэйж хуудсанд 4 удаа, мэдээллийн самбар болон Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд 44 удаа сул орон тоог зарласан зарыг нээлттэй байршуулсан.</p>	<p>“Хэрэгжих шатанд”- 100%</p>	
8	2	<p>Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” систем ашиглах журам батлах тухай № 2023-A/111 2023.02.07 Журмыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийслэлийн бүх шатны нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.</p>	<p>Газрын захирамжлалын баримт бичгийн бүртгэлд бүртгэж, 2023 оны 02 сарын 13-ны өдөр ажилтан албан хаагчдад төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн “eDoc” системээр зохион бүрдүүлэх, хүлээн авах, бүртгэх, шилжүүлэх, тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх, солилцох, шийдвэрлэлтэд хяналт тавих, тайлагнах, ангилан төрөлжүүлэх, хэрэг бүрдүүлэх, хадгалах, ашиглах болон мэдээллийн систем хэрэглэгчдийн эрхийн түвшинг тогтоох тухай танилцуулж мэдээллээр хангаж ажиллалаа.</p>	<p>“Хэрэгжих шатанд”- 100%</p>	

9	2	<p>Ажлын хэсэг байгуулах тухай №2023-А/172 2023.02.24</p> <p>Эдийн засгийн форум зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.</p>	<p>2023 оны 4 дүгээр сарын 21-ны өдөр Нийслэлийн Төр захиргааны цогцолбор байранд зохион байгуулагдах “Улаанбаатар хотын эдийн засгийн форум”-ын үйл ажиллагаанд байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд инженерийн байгууламж, хуралдааны танхимуудын техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах, цэвэрлэгээ үйлчилгээ, зоогийн үйлчилгээг стандартын дагуу үзүүлэн ажилласан.</p>	"Хэрэгжих шатанд"- 100%	
10	3	<p>Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай №2023-А/194 2023.03.10</p> <p>Стратегийн команд штабын сургуулийг өндөр түвшинд зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн болон Нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням)-т, идэвх санаачилгатай, бэлэн байдлыг хангаж оролцохыг нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагын удирдлага, албан хаагчдад тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагын харилцан” ажиллагаа сэдэвт стратегийн команд штабын сургуулийн дадлага, сургалтад байгууллагын нийт 35 ажилтан, албан хаагч хамрагдах бөгөөд 2023 оны 03 сарын 06-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт нэрсийг 2/65 дугаартай албан бичгээр хүргүүлсэн болно.</p>	"Хэрэгжих шатанд"- 100%	
11	3	<p>Гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулах тухай №2023-А/232 2023.03.15</p> <p>Дадлага, сургалтыг үр дүнтэй, өндөр түвшинд зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням)-т, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажилтан, албан хаагчдыг дадлага, сургалтад хамруулж, оролцоог хангахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын</p>	<p>“Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагын харилцан” ажиллагаа сэдэвт стратегийн команд штабын сургуулийн танхимын сургалтад байгууллагын нийт 83 ажилтан, албан хаагч хамрагдах бөгөөд 2023 оны 03 сарын 06-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт нэрсийг 2/65 дугаартай албан бичгээр хүргүүлсэн болно.</p>	"Хэрэгжих шатанд"- 100%	

		удирдлагуудад үүрэг болгосугай.			
Нийслэлийн Засаг даргын 11 захирамжийн 11 заалт хэрэгжилтийн дундаж хувь 94%					
5. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл					
1	2023.01.26	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд: Нийслэлийн хөгжлийн 2023 оны хэрэгжилтийг хангах, он дамжсан удаашралтай байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т, нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов" гэжээ.	Бодлогын баримт бичиг буюу Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 2 зорилтыг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус газарт он дамжсан удаашралтай байгаа заалтууд байхгүй болно.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	-
2	2023.01.26	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд: "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2022 оны хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т, нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов" гэжээ.	"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газарт тусгайлан хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд байгууллагын чиг үүргийн хүрээнд нийцүүлэн 6 заалтыг авч хэрэгжүүлэн 2022 оны жилийн эцсийн байдлаар дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ хийлгэж 100 хувь буюу "Бүрэн хэрэгжсэн" үнэлгээтэй байна.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	-
3	2023.01.26	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд: "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд явц удаашралтай, он дамжин хэрэгжиж байгаа арга хэмжээнүүдийг эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад	Тус газар нь "Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг үйл ажиллагаандаа нийцүүлэн, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 үйл ажиллагаа тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны 4-р улирлын байдлаар дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ хийлгэж 100 хувь буюу "Бүрэн хэрэгжсэн" үнэлгээтэй байна.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	-

4	2023.03.09	<p>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлд:</p> <p>Зам, тээврийн нэгдсэн системд шаардлагатай бодит мэдээ мэдээллийг түргэн шуурхай гаргах, системүүдийг нэгтгэж холбоход дэмжлэг үзүүлж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад;</p>	<p>Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг хэрэглэгчдийн сэтгэл ханамжид тулгуурлан тодорхойлж, цаашид нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой “Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах нь” судалгаанд Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 48 албан хаагч хамрагдсан.</p> <p>Зам, тээврийн нэгдсэн системд шаардлагатай бодит мэдээ мэдээллийн бэлэн байдлыг тогтмол ханган ажиллаж байна.</p>	”Хэрэгжих шатанд”- 70%	-
5	2023.03.09	<p>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлд: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад;</p>	<p>Тус газарт Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа байхгүй болно.</p>	”Бүрэн хэрэгжсэн”- 100%	-
6	2023.03.15	<p>Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлд: Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам” барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг дэмжиж ажиллахыг холбогдох чиглэл хариуцсан бүх шатны нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа байгууллагуудын удирдлагуудад тус тус үүрэг болгов” гэжээ.</p>	<p>Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам” барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг дэмжихтэй холбогдуулан шаардлагатай бодит мэдээ, мэдээллийн бэлэн байдлыг тогтмол ханган ажиллаж байна.</p>	”Хэрэгжих шатанд”- 70%	-

7		НЗД-ын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар хурлын тэмдэглэлд Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагын аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 03 дугаар улиралд багтаан тайлагнах, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхыг нийт төсвийн захирагч нар ... үүрэг болгов гэжээ.	2022 оны аудитын дүгнэлтээр ирүүлсэн найман зөвлөмжийн дагуу биелэлтийг гаргаж Нийслэлийн засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтэст 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 2/253 дугаар албан бичгээр тайлагнасан.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	
Нийслэлийн Засаг зөвлөлийн 4 удаагийн хурлын тэмдэглэл 7 заалт хэрэгжилтийн дундаж хувь 91%					
6. Нийслэлийн Иргэдийн хурлын төлөөлөгчдийн тогтоол					
1	1	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020.12.04 Дугаар 02/10 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө" дунд хугацааны бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилтийн явцад улирал бүр 8 заалтын хэрэгжүүлэн тайлан мэдээг гаргаж 1 удаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн холбогдох газарт заасан хугацаанд тайлагнаж ажиллаж байна.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	-
7. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол					
1	1	Журам батлах тухай 2017.06.07 Дугаар 90 "Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам"-ыг хавсралтаар баталсугай.	Уг тогтоолоор баталсан "Нийслэлийн эрх зүйн сан эрхлэн хөтлөх журам"-ын 2.1, 2.2 дугаар зүйлд тус тус заасны дагуу газрын даргын тушаалыг 54 тушаалыг нэгдсэн бүртгэл ublegal.mn сайтад оруулсан.	"Бүрэн хэрэгжсэн"- 100%	-
2	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хүртээмжийг сайжруулах тухай 2021.12.20 Дугаар 210 Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэг эрхийг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологиыг хүртээмжтэй болгох, барилга	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг ээлтэй, аюулгүй орчинд авах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд тайлант хугацаанд нийслэлийн засаг захиргааны байрууд, дэд төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарцыг сайжруулах, засварлах, орчин	"Хэрэгжих шатанд"- 70%	-

		<p>байгууламж, зам талбай, нийтийн тээврээр саадгүй зорчих эрхийг хангах чиглэлээр батлагдсан хууль, тогтоомжийг Нийслэлийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах холбогдох байгууллага албан тушаалтанд үүрэг, чиглэл өгч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Д.Сумъяабазар/- д үүрэг болгосугай.</p>	<p>нөхцөлийг бий болгохоор иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн ба НЗЗ-ны V байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зохиулсан ариун цэврийг өрөөг тохижуулж ашиглалтад оруулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин 8 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөгжил, нийгмийн оролцооны газрын дарга Б.Амаржаргал Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах хэрэгсэл болох 4 ширхэг тэргэнцрийг 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэргэжилтэн Б.Болороо Үйлдвэрлэл, үйлчилгээний алба, Инженерийн байгууламж ашиглалт, үйлчилгээний албаны албан хаагчдад “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэх” нь сургалт орсон. Үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд Нийслэлийн Засаг захиргааны I, II, IV, Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор байраар үйлчлүүлэх ээлтэй орчныг бүрдүүлсэн.</p>		
7 захирамжлалын баримт бичгийн 49 заалтын хэрэгжилтийн дундаж хувь: 90,8%					

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын 5 хуулийн 9 заалт, Засгийн газрын 8 тогтоолын 18 заалт, Монгол улсын Ерөнхий сайдын албан даалгаврын 1 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 тогтоолын 1 заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2 тогтоолын 2 заалт, Нийслэлийн Засаг даргын 11 захирамжийн 11 заалт, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын 4 тэмдэглэлийн 7, нийт 7 захирамжлалын баримт бичгийн 49 заалтыг 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 90,8 хувийн биелэлттэй гэж дүгнэлээ.

Нийт 49 зүйл, заалтаас “бүрэн хэрэгжсэн” 100 хувийн биелэлттэй 34, “хэрэгжих шатанд” 70 хувийн биелэлттэй 15, “хэрэгжилт хангалтгүй”, “Хэрэгжээгүй” болон үнэлгээ өгөөгүй зүйл, заалт байхгүй болно.

2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад авсан 28 тогтоол шийдвэрийн 45 заалтын хэрэгжилт 70 хувь үнэлэгдэж байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 32 захирамжлалын баримт бичгийн 49 заалтын хэрэгжилт 90.8 хувь үнэлэгдэж, эхний хагас

жилээс биелэлтээс 20,8%-иар өссөн дүнтэй боловч 2023 оны сүүлийн хагас жилийн хугацаанд хяналтад 4 шийдвэрийн 4 заалтыг нэмж авсан нь хангалтгүй байна гэж үзлээ.

Цаашид дээд газрын тогтоол шийдвэрийг бүртгэх, хяналтад авч, хэрэгжилтийг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнахдаа дараах зөвлөмжийг анхаарч ажиллана уу.

1. Нийт төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хамаарч эсхүл үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй холбогдуулан гарсан захирамжлалын баримт бичгийг албан бичгээр хүлээн авахаас гадна олон сувгаар, цаг алдахгүй хяналтад авч удирдлагыг мэдээллээр хангах, бүртгэлжүүлэх, /Жишээ нь Монгол Улсын Засгийн газрын 2023.12.13-ны өдрийн 301 тогтоолыг хяналтад авах/

2. Хяналтад авсан тогтоол шийдвэрийг газрын даргад танилцуулах холбогдох албан хаагчид цохолт хийлгэх, хяналтын хуудсаар үүрэгжүүлэн ажиллах, хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцсан ажилтнаас биелэлтийг үнэн зөв гаргуулан авч хэвших,

3. Төрийн албаны тухай 55.3 заалтын хэрэгжилтийн тухайд:

- Байгууллагын сургалтын төлөвлөгөөг 2023 оны 02 дугаар сард батлуулсан боловч, хэрэгжилтийг нэгтгэн гаргаагүй, энэ онд зохион байгуулагдсан сургалтын жагсаалтыг 2023 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт нэрээр өөрчлөн гаргасан зөрчил илэрсэн тул биелэлт нэгтгэхдээ холбогдох ажилтан батлагдсан төлөвлөгөөний дагуу үнэн зөв тайлагнаж буй эсэхэд хяналт тавих, ажилтнаас батлагдсан төлөвлөгөөг шаардах,
- Байгууллага албан хаагчдын сургалтын төлөвлөгөө болон ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөнд хэдэн арга хэмжээ төлөвлөсөн, 2023 оны жилийн эцсийн байдлаар хэдэн хувийн биелэлттэй байгаа талаар үнэн зөв мэдээллийг тусгах,

4. Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой ажлууд хийгдсэн, хэсгийн дундаж хувийг тооцсон боловч хэрэгжилтийг тайлагнахдаа гол үр дүнг товч тодорхой, тоон мэдээлэл, баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнаагүй, хэт нуршуу, цэгцгүй байна. Шаардлагатай нотлох баримтыг хавсаргах, бичвэрийг 2000 /хоёр мянган/ тэмдэгтэд багтаах шаардлагатай байна. /Тухайн чиглэлийн төлөвлөгөө, биелэлт, холбогдох судалгаа, тоо мэдээ, зураг гэх мэт/

5. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэлбэрийн шаардлагыг хангах, биелэлтийн хүснэгтийг холбогдох журмын 5 дугаар хавсралтаар тайлагнах,

6. Хэрэгжилтийн явцыг тайлагнахгүй, хэрэгжээд дууссан өнгөрсөн цаг дээр тайлагнах, үг үсэг, утга агуулга, хэл найруулгад анхаарах, шийдвэрийн хэрэгжилт тус бүрийн үр дүн, үр нөлөөг тооцдог байх,

5. Тухайн чиглэлээр хийгдсэн ажлыг бүрэн хамруулах,

6. Судалгаа, тоо баримтад үндэслэсэн байх,

8. Хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор баталсан журмын 5 дугаар хавсралтын дагуу нэгтгэн боловсруулж, захиргааны ахлах мэргэжилтэн, хэлтсийн даргаар хянуулан, албажуулах,

9. Хэрэгжилтийг хагас жилээр 06 дугаар сарын 25, бүтэн жилээр 12 дугаар сарын 25-ны дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх бөгөөд эцэслэсэн тайланг энэ

хугацаанаас ажлын 5 хоногийн өмнө Дотоод хяналт- шинжилгээ үнэлгээний ажилтанд ирүүлэх,

10.Байгууллагын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дүн шинжилгээ хийсэн тайланг холбогдох албан хаагчдаар хянуулан, газрын даргад танилцуулах, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэлийн хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан бичгээр хүргүүлэх,

ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЗОЛБАЯР

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Б.УУГАНЦЭЦЭГ